



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА  
Ц.БАТЗУЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn  
Вэб сайт: meds.gov.mn

2023.12.22 № 2/6210  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хариу хүргүүлэх тухай**

Ерөнхий боловсролын сургуульд цахим анги байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг ерөнхий гэрээгээр худалдан авах төсөл арга хэмжээнд оролцохыг сонирхсон этгээдээс ирүүлсэн тодруулгатай танилцан судаллаа. Тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Ухаалаг дэлгэц нь android болон Windows гэсэн 2 үйлдлийн системтэй байна.

- Android 11 үйлдлийн систем: CPU-A55 4Cores, RAM-4GB DDR4, Storage-32/64GB болон түүнээс дээш;
- Windows 11 үйлдлийн систем: CPU-i5, RAM-8GB DDR4, Storage-128GB болон түүнээс дээш гэж ойлгоно.

2. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль болон бусад салбарын хуулийг шинэчлэн баталсан. Энэхүү хуулиуд 2023 оны 8 дугаар сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10. дахь хэсэг “39.10.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг арилжааны хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн гэрээгээр хоёр буюу түүнээс дээш жилийн хугацаатай эзэмших, ашиглах, худалдан авах зардал”, гэж тусгагдсан. Мөн Боловсролын ерөнхий хуулийн Боловсрол шинжлэх ухааны яамнаас Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.12-ын 10-т “Багш бүрийг компьютержуулж, “Ухаалаг сургууль”, “Ухаалаг анги” төсөл хэрэгжүүлнэ” гэж заасан.

Боловсролын салбарын төсөв, санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоолоор батлагдсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нэг суралцагчид нотлох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд “Цахим хэрэглээний зардал”, “Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал”-ыг тус тус тусгасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль нь улсын төсвөөс сар бүр олгогддог хувьсах зардлаар санхүүжигдэн үйл ажиллагаагаа явуулдаг. Ерөнхий боловсролын сургууль нь цахим танхим байгуулахдаа Төсвийн тухай хуулийн 29.3.2-т заасны дагуу тухайн жилийн хүрээнд дээр дурдсан хувьсах

14239 6233

зардлын бүрэлдэхүүнд туссан зардлаас төлбөрийг санхүүжүүлнэ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 100 дугаар тогтоол гарсан. Энэхүү тогтоолын 1.1 дэх заалтад "боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын цахим шилжилтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн анги танхимыг интернэт, дотоод сүлжээнд бүрэн холбох, багш бүрийг компьютержуулах, хүүхдийн авьяасыг дэмжих, цахим системд суурилсан нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр зохион байгуулах" гэж заасан тул эдгээр арга хэмжээг цаашид зохион байгуулах бүрэн боломжтой юм.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН

